



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 146 дугаар тогтоолын 4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрыг “Эрчис ойл” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид нэгтгэхээр шийдвэрлэсэнтэй холбогдуулан үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тооны хамт “Эрчис ойл” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсэг ажиллахад шаардагдах зардлыг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын холбогдох эх үүсвэрээс зарцуулсугай.

4. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө шилжүүлэх асуудлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003201

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2025 оны 05 дүгээр сарын 14-ны өдрийн
А/28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч	Ц.Баяр-Эрдэнэ	/Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга/
Гишүүд:	Ч.Хишигдалай	/Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, зөвшилцсөнөөр/
	Д.Нарангэрэл	/Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга/
	М.Баярмаа	/Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	О.Ишханд	/Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Х.Эрдэнэбилэг	/“Эрчис ойл” ТӨХХК-ийн Санхүүгийн албаны дарга, зөвшилцсөнөөр/
	Б.Хадбаатар	/“Эрчис ойл” ТӨХХК-ийн хяналтын албаны дарга, зөвшилцсөнөөр/
	Г.Гансүх	/“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал/
	Б.Дэлгэрдалай	/“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч/
Нарийн бичгийн дарга	Т.Мөнхзаяа	/“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий инженер/
	Д.Одмаа	/Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2025 оны 03 дүгээр сарын 14 ны өдрийн
1/28 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг: Зорилго. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 146 дугаар тогтоолын 4-т заасны дагуу “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрыг үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тооны хамт “Эрчис Ойл” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлэх ажлын хүрээнд Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл.

1. Үйлдвэрийн газрын үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөд тооллого хийж, санхүүгийн тайлантай тулган баталгаажуулалт хийх, акт үйлдэх, хөрөнгө хүлээн авах эрх хүлээн авагчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

2. Төсвийн болон бусад өр төлбөр, ажиллагсадтай хийх өр, авлагын тооцоог хийж актаар баталгаажуулах;

3. Орон тоог шилжүүлэн авах, тэдгээртэй холбоотой санхүүгийн тооцоо гаргах, цалин, хөлс, нийгмийн даатгалыг тасалдуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахад дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын нийгмийн баталгаа, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх арга хэмжээ авах;

4. Үйлдвэрийн газрын дуусаагүй худалдан авалт, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, судалгаа шинжилгээний бүтээл зэргийн эрхийг холбогдох хууль журмын дагуу хүлээлцэх;

5. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад шилжүүлж, эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулах;

6. Архив, албан хэргийн материалыг акт үйлдэн эрх хүлээн авагчид шилжүүлэн өгөх;

7. Санхүүгийн хаалтын тайлан тэнцэл гаргах;

Гурав: Хугацаа, үр дүн. Ажлын хэсэг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрыг үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг зохих журмын дагуу балансаас балансад орон тооны хамт “Эрчис Ойл” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлэх ажлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэх.

----- о о о -----